

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

№ 25/47

Улаанбаатар хот

**Тооллогын комиссын тайланг
баталгаажуулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.11 дахь хэсэг болон 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 24-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)–ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (“ХЭЭБХ”)–ын Тооллогын комиссын 2025 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн 01 тоот тайлан болон Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн (цаашид “ТУЗ”)–ийн 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн ТУЗ–ийн 2025 оны 09 дүгээр сарын 03-ны өдрийн 25/42 дугаар тогтоолоор ХЭЭБХ–ыг эчнээ санал хураалтын хэлбэрээр 2025 оны 09 дүгээр сарын 25-ны өдрөөс 10 дугаар сарын 24-ний өдрийн хооронд зохион байгуулахаар шийдвэрлэснийг дурдсугай.
2. Энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт дурдсан ХЭЭБХ–ийн эчнээ санал хураалтаар нийт саналын эрх бүхий хувьцааны **81.16%**-тай тэнцэх хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчдээс (i) “АНД Системс” ХХК–иас хоёрдогч өглөг хэлбэрээр Компанийн хоёрдугаар зэрэглэлийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх, (ii) Компанийн дүрэмд оруулах нэмэлт, өөрчлөлтийг батлах асуудлуудыг тус бүрээр дэмжсэн буюу зөвшөөрсөн санал ирүүлсэн тухай үр дүнгийн тайланг Тооллогын комисс гаргаж Төлөөлөн Удирдах Зөвлөлд танилцуулсан болохыг баталгаажуулсугай.
3. Компанийн ХЭЭБХ–ын эчнээ санал хураалтын үр дүнгийн тухай Тооллогын комиссын тайлан, түүнийг үндэслэн гарсан ХЭЭБХ–ын шийдвэр болон холбогдох хууль тогтоомжид заасан бусад баримт бичгийг “Санхүүгийн зохицуулах хороо” болон “Монголын хөрөнгийн бирж” ХК (“МХБ”)–д хүргүүлэхийг ТУЗ–ийн Нарийн бичгийн дарга (Х.Хулан)–д үүрэг болгосугай.
4. ХЭЭБХ–ын шийдвэрийг МХБ–ийн цахим хуудас, Компанийн цахим хуудас, өдөр тутмын сонин, цахим орчин дахь албан ёсны хаягаар болон бусад хэвлэл мэдээллийг хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА

О.БОЛДБААТАР

Улаанбаатар хот

ТУЗ-ийн
лэндмйн бөгөөд
лэндм
ОБОЛД
УЛААНБААТАР ХОТ
5039754 Ш.1118267206

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

№ 25/49

Улаанбаатар хот

**Гүйцэтгэх захирлын Репо арилжаанд
оролцох эрхийг нэмэгдүүлэх тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.22, 9.6.23 дахь заалт, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн 2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн 22/12 тоот тогтоол, 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн 22/26 тоот тогтоол, 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 23/04 тоот тогтоол болон Компанийн ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн эх үүсвэрийг үр ашигтай удирдах зорилгоор Репо арилжаанд зээлдэгч болон зээлдүүлэгчийн хувиар оролцоход баримтлах арилжааны хэмжээг энэхүү тогтоолын хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Энэхүү тогтоолоор шинэчлэгдсэн батлагдсан арилжааны хэмжээний дагуу Репо арилжаанд оролцох, арилжааны хэмжээ нэмэгдсэнтэй холбогдуулан Компанийн хэвийн зээлийн багцыг нэмэгдүүлсэн хэмжээнээс тооцон нэмж барьцаалах, эдгээр үйл ажиллагааны хүрээнд “Мони Маркет Фанд” ХХК-тай нэмэлт гэрээ, хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
3. Репо арилжаанд Компанийн эрх ашиг болон дотоод бодлогод нийцүүлэн оновчтой оролцох, үр ашигтай түвшинд удирдан зохион байгуулж ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д даалгасугай.
4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Компанийн ТУЗ-д тогтмол тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

№ 25/50

Улаанбаатар хот

Зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17, 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, 89 дүгээр зүйлийн 89.1 дэх заалт, 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4, 9.6.20, 9.6.23 дахь заалт, 14 дүгээр зүйлийн 14.5.4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4, 20.5 дахь хэсэг, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид “ТУЗ”)-ийн дэргэдэх Аудитын хорооны 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн АХ-25/09 тоот дүгнэлт болон Компанийн ТУЗ-ийн 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн толгой компани болох “АНД Системс” ХХК-ийн 100 хувийн эзэмшлийн охин компани болох “Супер Ап Хэтэвч” ХХК-ийг бүхэлд нь нийт 2,626,057,102 (хоёр тэрбум зургаан зуун хорин зургаан сая тавин долоон мянга нэг зуун хоёр) төгрөгөөр худалдан авахаар шийдвэрлэсүгэй.
2. “АНД Системс” ХХК-тай байгуулах “Супер Ап Хэтэвч” ХХК-ийг худалдах, худалдан авах гэрээний нөхцөлийг энэхүү тогтоолын хавсралтаар баталсугай.
3. Энэхүү тогтоолын хавсралтад заасан нөхцөлийн хүрээнд “АНД Системс” ХХК-тай холбогдох гэрээ, хэлцлүүдийг байгуулах, тэдгээрт гарын үсэг зурах, энэхүү тогтоолын 1 дэх хэсэгт заасантай холбогдуулан “Супер Ап Хэтэвч” ХХК-ийг худалдан авахад шаардагдах аливаа хувьцаа эзэмшигчийн шийдвэрийг гаргах, баталгаажуулах эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д олгосугай.
4. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэх, үр дүнг Компанийн ТУЗ-д эргэн тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.



О.БОЛДБААТАР